



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 307

Улаанбаатар хот

Г Үндсэн хөрөнгө худалдах, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 11 нэрийн, нийт 499,045.34 (дөрвөн зуун өрөн есөн мянга дөчин таван ам.доллар гучин дөрвөн цент) ам.долларын балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрч, худалдах (сэлбэг) доод үнийг хавсралтаар тогтоосугай.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайд, Ерөнхий консул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгө худалдсанаас олох орлогыг зохих журмын дагуу байгууллагынхаа дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001371

14-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2025 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн
30.2 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСАAS ГАДААД УЛСАД СУУГАА ДИПЛОМАТ ТӨЛӨӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУЛЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАЖ, ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Автомашины марк, улсын дугаар, зориуулалт, хөдөлгүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (ам.доллар)	Худалдах доод үнэ (ам.доллар)	Байршил (Элчин сайдын яам)
1	Опел Инсигниа Лимузина НБ маркийн судлын, С 62-05 дугаартай, Арлын дугаар - W0LGM5ECXB1105756	2011	141979	24,599.00	1,000.00	Софи ЭСЯ
2	Тойота Проэйс маркын бага оврын автобус, W77509 дугаартай, Арлын дугаар - YARVVEEHZ8GZ132215	2018	150000	36,413.17	1,000.00	Варшав ЭСЯ
3	Mercedes Benz S300L8 S3901 CD дугаартай, Арлын дугаар - WDD2211542A525287	2013	127223	110,742.67	1,000.00	Сингапур ЭСЯ
4	Мерседес Бенз, S-400 маркийн судлын автомашин, Улсын дугаар: 02-213, Арлын дугаар - WDDUG6FB1FA114901	2014	76632	91,962.83	1,000.00	Эль-Кувейт ЭСЯ
5	Nissan Primastar микробус, LGK448 улсын дугаартай, Арлын дугаар VSKJ4BJBSUY631246	2011	225000	18,706.99	500.00	Стокхолм ЭСЯ

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (ам.доллар)	Худалдах доод үнэ (ам.доллар)	Байршил (Элчин сайдын яам)
6	ЭСЯ-ны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа D012041 улсын дугаартай, арлын дугаар- WV2ZZZ7HZCH006401 VOLKSWAGEN CARAVELLE заварын, цагаан өнгийн, микроавтобус,	2010	153787	56,000.00	1,000.00	Астана дах ЭСЯ
7	Unizuki загварын LC5BABJ600000396 серийн дугаартай цахилгаан мопед	2020		2,500.00	300.00	Хавана ЭСЯ
8	Mercedes-benz S350	2013	320276	62,769.33	1,000.00	Берлин ЭСЯ
9	Автомашины чиргуул	2010		522.85	50.00	Берлин ЭСЯ
10	Пассат Волксваген	2013		24,107.14	800.00	Берлин ЭСЯ
11	Ланд круизер-200 маркийн жил, 089D01003 Дугаартай, Арлын дугаар -JTMNX05J304040176	2014	341000	70,721.36	15000.00	Улаан-Уд ЕКР
НИЙТ ДҮН				499,045.34	8,650.00 (найманмянга зургаан зуун тавь)	(дервөн зуун ерэн есөн сая дөчин таван мянгган ам.доллар гучин дервөн цент)